



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН 2018 ОНЫ
НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2018 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2018.05.24


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо 288-д хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6-аар буюу 2.1 хувиар өссөн, өмнөх оны жилийн эцсээс 2-оор буюу 0.6 хувиар буурсан үзүүлэлт юм.

ХЗХ-дын тооны өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулж харуулбал:

/График 1/



Тайлант улиралд Хорооноос шинээр 9 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 39 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 11 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн. Мөн 11 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 2 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээсэн байна.

ХЗХ-ны үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэсэн байдлыг он болон төрөл тус бүрээр харуулбал:

/Хүснэгт 1/

Он	Шинээр олгосон	Хүчингүй болгосон	Түдгэлзүүлсэн	Сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо
2014 он	25	7	7	3	28	159
2015 он	98	4	1	1	21	253
2016 он	34	7	2	-	48	280
2017 он	17	8	21	4	54	290
2018.I улирал	9	11	11	2	39	288

Тайлант улиралд Хорооны даргын тушаалаар 1 ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг шийдвэрлэсэн. Мөн 15 ХЗХ-ны сонгуульт гишүүд, гүйцэтгэх албаны өөрчлөлт, 8 ХЗХ-ны оршин байх хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэсэн.

ХЗХ-дыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулбал:


/Хүснэгт 2/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ХЗХ-дын тоо	
		2017.I	2018.I
1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	282	288
Үүнээс:			
2	Төслийн санхүүжилтийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй	123	118
3	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	1	2
4	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	1	2
5	Салбарын зөвшөөрөлтэй	5	6

Нийт 118 ХЗХ төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байгаагийн 115 ХЗХ нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Эдгээр ХЗХ-дын 110 нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд шинээр байгуулагдсан хоршоод юм.


/График 2/

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 288 ХЗХ-ны 64.6 хувь буюу 186 ХЗХ Улаанбаатар хотод, 35.4 хувь буюу 102 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.



/График 3/

Улаанбаатар хотын 9 дүүрэгт ХЗХ-д үйл ажиллагаа эрхэлж байгаагаас хүн ам ихтэй Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байгаа бол Багахангай дүүрэгт 2 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.



Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд 21 аймагт тархалттай байна. Орхон, Баян-Өлгий, Завхан аймгуудад ХЗХ ихээр төвлөрсөн байгаа бол Сэлэнгэ, Говьсүмбэр аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.


/Зураг 1/



ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 57,659-д хүрчээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,741-ээр нэмэгдсэн буюу 20.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт гишүүдийн 33,360 нь буюу 57.9 хувь нь эмэгтэй гишүүд байна.

Нийт гишүүдийн 64.5 хувь буюу 37,176 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд, 35.5 хувь буюу 20,483 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 26.8 хувь буюу 9,943 нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын гишүүд байна.

График 4/



/График 5/

Гишүүнчлэлийн хувьд нийт ХЗХ-дын 165 буюу 57.2 хувь нь 20-100 гишүүнтэй, 105 буюу 36.5 хувь нь 101-500 гишүүнтэй, 10 буюу 3.5 хувь нь 501-1000 гишүүнтэй, 8 буюу 2.8 хувь нь 1001-ээс дээш гишүүнтэй байна.



Гишүүнчлэлийн байдлыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 3/

№	Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх %
1	20-100 гишүүнтэй	165	8,669	57.2 %
2	101-500 гишүүнтэй	105	21,449	36.5 %
3	501-1000 гишүүнтэй	10	5,969	3.5 %
4	1001-с дээш гишүүнтэй	8	21,572	2.8 %
	Нийт	288	57,659	100%

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй 288 ХЗХ-ны санхүүгийн үзүүлэлт нэгтгэлд хамрагдахаас 2018 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлан мэдээгээ Хороонд ирүүлээгүй 28 ХЗХ-ны санхүүгийн үзүүлэлтийг өмнөх улирлын дүнгээр, 7 ХЗХ эхлэлтийн тайлангийн дүнгээр хамрагдлаа.

2.1 Статистик үзүүлэлтүүд

/Хүснэгт 4/


СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ 288 ХЗХ-НЫ ГИШҮҮД		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот дахь 186 ХЗХ		Орон нутаг дахь 102 ХЗХ	
Гишүүдийн насжилт	57,659	100%	37,176	100%	20,483	100%
18-35 насны	17,361	30.1%	11,661	31.3%	5,700	27.9%
36-45 насны	17,687	30.7%	11,352	30.6%	6,335	30.9%
46-55 насны	13,684	23.7%	8,441	22.7%	5,243	25.6%
55-аас дээш	8,920	15.5%	5,717	15.4%	3,203	15.6%
Гишүүдийн боловсрол	57,659	100%	37,176	100%	20,483	100%
Дээд	26,085	45.2%	19,588	52.6%	6,497	31.8%
Тусгай дунд	8,420	14.6%	5,239	14.1%	3,181	15.6%
Бүрэн дунд	12,443	21.6%	6,943	18.7%	5,500	26.8%
Дунд	9,145	15.9%	4,821	13%	4,324	21.1%
Бага	1,456	2.5%	477	1.3%	979	4.7%

Нийт ажилтнуудын тоо	828	100%	565	100%	263	100%
Эмэгтэй ажилтнуудын тоо	610	73.9%	410	72.5%	200	76.3%
Санхүүгийн програм хангамжийн тоо	77		32		45	

ХЗХ-ны гишүүдийн насжилт болон боловсролын байдлыг графикаар харуулбал:

/График 6/

/График 7/



ХЗХ-дын нийт гишүүдийн дунд 18-45 насныхан зонхилох байр суурийг эзэлж байгаа бол, нийт гишүүдийн 45 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

/Хүснэгт 5/ (мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017 оны I улирал	2018 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	282	288	6	2.1%
2	Гишүүдийн тоо	47,918	57,659	9,741.0	20.3%
3	Нийт актив	121,698,281.4	160,768,588.7	39,070,307.3	32.1%
4	Банкны салбарт эзлэх хувь	0.5%	0.6%	0.1%	
5	Нийт зээлийн үлдэгдэл	96,733,750.1	117,942,219.5	21,208,469.4	21.9%
6	Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.8%	0.1%	
7	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	4,484,903.8	6,682,613.3	2,197,709.5	49.0%
8	Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.6%	5.7%	1.0%	
9	Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.5%	0.1%	
10	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	74,658,800.4	107,998,368.0	33,339,567.6	44.7%
11	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	0.7%	(0.1%)	
12	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	13,421,048.9	14,745,229.7	1,324,180.8	9.9%
13	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	10,053,107.1	13,417,761.8	3,364,654.7	33.5%
14	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	16,833,370.5	16,731,312.7	(102,057.8)	-0.6%
15	Нийт орлого	6,934,210.3	9,764,737.6	2,830,527.3	40.8%
16	Нийт зардал	6,450,139.9	9,301,864.7	2,851,724.8	44.2%
17	Цэвэр орлого, алдагдал	484,070.4	462,872.9	(21,197.5)	-4.4%

Тайлант улиралд ХЗХ-ны тоо өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар, гишүүдийн тоо 20.3 хувиар, нийт активын хэмжээ 32.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Салбарын нийт зээлийн банкны салбарт эзлэх хувь 0.1 пунктээр өссөн бол нийт хадгаламжийн банкны салбарт эзлэх хувь 0.1 пунктээр буурсан, чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 49.0 хувиар өссөн байна. Нийт орлого 40.8 хувиар, нийт зардал 44.2 хувиар өсч нийт ашиг 4.4 хувиар буурсан байна.

2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/Хүснэгт 6/ (мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017 оны I улирал	2018 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	185	186	1.0	0.5%
2	Гишүүдийн тоо	27,696	37,176	9,480.0	34.2%
3	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	57.8%	64.5%		
4	Нийт актив	105,108,897.1	140,581,604.7	35,472,707.6	33.7%
5	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	86.4%	87.5%		
6	Нийт зээлийн үлдэгдэл	83,908,527.7	102,397,441.3	18,488,913.6	22.0%
7	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	86.7%	86.9%		
8	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	3,939,645.7	6,298,394.2	2,358,748.5	59.9%
9	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	87.8%	94.3%		
10	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	65,601,318.4	96,179,088.1	30,577,769.7	46.6%
11	ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	87.9%	89.1%		
12	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	9,680,182.4	10,665,466.5	985,284.1	10.2%
13	ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	72.1%	72.3%		
14	Нийт хоршоологчдын өмчийн дүн	7,821,148.2	10,735,463.5	2,914,315.3	37.3%
15	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	77.8%	80.1%		
16	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	16,084,449.5	16,121,380.0	36,930.5	0.2%
17	Нийт орлого	5,477,565.8	8,155,170.2	2,677,604.4	48.9%
18	Нийт зардал	5,211,691.4	7,905,904.5	2,694,213.1	51.7%
19	Цэвэр орлого, алдагдал	265,874.4	249,265.8	(16,608.6)	-6.2%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 186 ХЗХ-ны нийт актив 140,581,604.7 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 87.5 хувийг, нийт орлого 8,155,170.2 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт орлогын 83.5 хувийг, нийт зардал 7,905,904.5 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 85.0 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант улиралд Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 34.2 хувиар, нийт актив хөрөнгө 33.7 хувиар, нийт зээлийн хэмжээ 22.0 хувиар тус тус өссөн байна.

2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/Хүснэгт 7/ (мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017 оны I улирал	2018 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь

1	ХЗХ-дын тоо	97	102	5	5.2%
2	Гишүүдийн тоо	20,222	20,483	261	1.3%
3	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	42.2%	35.5%		
4	Нийт актив	16,589,384.3	20,186,983.9	3,597,599.6	21.7%
5	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	13.6%	12.5%		
6	Нийт зээлийн үлдэгдэл	12,825,222.4	15,544,778.2	2,719,555.8	21.2%
7	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	13.3%	13.1%		
8	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	545,258.1	384,219.1	(161,039.0)	-29.5%
9	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	12.2%	5.7%		
10	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	9,057,481.9	11,819,279.9	2,761,798.0	30.5%
11	ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	12.1%	10.9%		
12	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	3,740,866.5	4,089,763.3	348,896.8	9.3%
13	ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	27.9%	27.7%		
14	Нийт хоршоологчдын өмчийн дүн	2,231,958.8	2,682,298.3	450,339.5	20.2%
15	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	22.2%	19.9%		
16	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	748,921.0	609,932.7	(138,988.3)	-18.6%
17	Нийт орлого	1,456,644.4	1,609,567.4	152,923.0	10.5%
18	Нийт зардал	1,238,448.4	1,395,960.2	157,511.8	12.7%
19	Цэвэр орлого, алдагдал	218,196.0	213,607.2	(4,588.8)	-2.1%

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 102 ХЗХ-ны нийт актив 20,186,983.9 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 12.5 хувийг, нийт орлого 1,609,567.4 мянган төгрөг байгаа нь нийт орлогын 16.5 хувийг, нийт зардал 1,395,960.2 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 15.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт чанаргүй зээлийн хувьд 29.5 хувиар буурч, нийт ашгийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2.5 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/Хүснэгт 8/ (мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017 оны I улирал	2018 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	118	110	-8	-1.7%
2	Гишүүдийн тоо	9,485	9,943	458	10.3%
3	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	19.8%	17.2%	-2.6%	
4	Нийт актив	13,478,756.9	13,574,328.9	95,572.0	12.0%
5	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	11.1%	8.4%	-2.7%	
6	Нийт зээлийн үлдэгдэл	11,997,002.5	11,446,022.9	(550,979.6)	2.8%
7	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	12.4%	9.7%	-2.7%	

8	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	339,334.5	249,828.6	(89,505.9)	2.7%
9	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	7.6%	3.7%	-3.9%	
10	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	1,096,459.9	1,879,264.3	782,804.4	101.8%
11	ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	1.5%	1.7%	0.2%	
12	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	731,643.6	1,046,979.4	315,335.8	71.6%
13	ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	5.5%	7.1%	1.6%	
14	Нийт хоршоологчдын өмчийн дүн	-151,446.5	189,186.7	340,633.2	151.4%
15	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	-1.5%	1.4%	2.9%	
16	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	11,623,912.8	10,194,054.9	(1,429,857.9)	-1.5%
17	Нийт орлого	568,468.4	650,375.4	81,907.0	24.0%
18	Нийт зардал	676,193.1	655,597.0	(20,596.1)	14.1%
19	Цэвэр орлого, алдагдал	-107,724.7	-5,221.6	102,503.1	156.0%

“Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 110 ХЗХ-ны нийт актив 13,574,328.9 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 8.4 хувийг, нийт орлого 650,375.4 мянган төгрөг байгаа нь нийт орлогын 6.7 хувийг, нийт зардал 655,597.0 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 7.1 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант улиралд уг хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын цэвэр орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 156.0 хувиар өсч 102,503.1 мянган төгрөгөөр алдагдлаа бууруулсан байна. Тайлант хугацаанд 110 ХЗХ-ноос 66 ХЗХ нь 96,402.2 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажиллаж, 2 ХЗХ ашиг, алдагдалгүй, 42 ХЗХ 101,623.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бол тус ХЗХ-дын зээлийн хүүгийн орлого 592,438.2 мянган төгрөг байхад үйл ажиллагааны зардал 484,651.1 мянган төгрөг байна.

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтэц

ХЗХ-дын тайлант улирлын нийт хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/ (мянган төгрөгөөр)


№	ХӨРӨНГӨ	2017 оны I улирал		2018 оны I улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		118,812,037.6	97.6%	156,967,758.1	97.6%	38,155,720.5	32.1%
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,026,700.0	16.5%	33,586,242.3	20.9%	13,559,542.3	67.7%
	Бэлэн мөнгө	2,546,711.0	2.1%	2,968,250.0	1.8%	421,539.0	16.6%

	Банкинд байршуулсан харилцах	7,187,989.6	5.9%	7,082,122.7	4.4%	-105,866.9	-1.5%
	Банкинд байршуулсан хадгаламж	10,291,999.4	8.5%	23,537,042.1	14.6%	13,245,042.7	128.7%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-	-	-
	Арилжааны үнэт цаас	-	-	-	-	-	-
1.3	ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/	93,437,634.6	76.8%	114,751,354.9	71.4%	21,313,720.3	22.8%
	Нийт зээл	96,733,750.1	79.5%	117,942,219.5	73.4%	21,208,469.4	21.9%
	Хэвийн зээл	87,220,700.6	71.7%	107,003,148.9	66.6%	19,782,448.3	22.7%
	Хугацаа хэтэрсэн зээл	5,028,145.6	4.1%	4,256,457.3	2.6%	-771,688.3	-15.3%
	Чанаргүй зээл	4,484,903.8	3.7%	6,682,613.3	4.2%	2,197,709.5	49.0%
	Хэвийн бус зээл	1,339,030.0	1.1%	4,173,607.3	2.6%	2,834,577.3	211.7%
	Эргэлзээтэй зээл	943,963.6	0.8%	1,242,154.2	0.8%	298,190.6	31.6%
	Муу зээл	2,201,910.3	1.8%	1,266,851.8	0.8%	-935,058.5	-42.5%
	(Зээлийн эрсдэлийн сан)	3,296,115.5	2.7%	3,190,864.6	2.0%	-105,250.9	-3.2%
1.4	АВЛАГА	4,138,107.3	3.4%	6,792,628.2	4.2%	2,654,520.9	64.1%
	Байгууллага, хүмүүсээс авах авлага	474,705.0	0.4%	1,930,068.5	1.2%	1,455,363.5	306.6%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,663,402.3	3.0%	4,862,559.7	3.0%	1,199,157.4	32.7%
1.5	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	394,369.5	0.3%	1,154,450.9	0.7%	760,081.4	192.7%
	Татварын авлага	423,518.4	0.3%	15,730.2	0.0%	-407,788.2	-96.3%
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	96,148.9	0.1%	602,285.3	0.4%	506,136.4	526.4%
	Дараа тайлангийн тооцоо	23,544.5	-	212,676.3	0.1%	189,131.8	803.3%
	Дутагдал, шамшигдал	115,020.8	0.1%	114,507.0	0.1%	-513.8	-0.4%
	Хангамжийн зүйлс	117,303.8	0.1%	209,252.1	0.1%	91,948.3	78.4%
	Салбар хоорондын авлага	-	-	-	-	-	-
1.6	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВЭР/	815,226.2	0.7%	683,103.8	0.4%	-132,122.4	-16.2%
	Өмчлөх бусад хөрөнгө	857,571.5	0.7%	757,901.3	0.5%	-99,670.2	-11.6%
	(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	42,345.4	-	74,797.5	0.0%	32,452.1	76.6%
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		2,886,243.7	2.4%	3,800,830.6	2.4%	914,586.9	31.7%
2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВЭР/	2,854,268.8	2.3%	3,748,928.7	2.3%	894,659.9	31.3%
	Үндсэн хөрөнгө	3,536,238.6	2.9%	4,611,110.8	2.9%	1,074,872.2	30.4%
	(Хуримтлагдсан элэгдэл)	681,969.8	0.6%	862,182.1	0.5%	180,212.3	26.4%
2.2	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	16,954.9	-	36,186.4	-	19,231.5	113.4%
	Биет бус хөрөнгө	18,624.1	-	39,439.1	-	20,815.0	111.8%
	(Биет бус хөрөнгийн элэгдэл)	1,669.2	-	3,252.7	-	1,583.5	94.9%
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БУСАД ХӨРӨНГӨ	15,020.0	-	15,715.5	-	695.5	4.6%
2.3	Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.0	-	15,715.5	-	695.5	4.6%
ХӨРӨНГИЙН ДҮН		121,698,281.4	100%	160,768,588.7	100%	39,070,307.3	32.1%

ХЗХ-дын нийт актив хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.1 хувиар буюу 39,070,307.3 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Тайлант улиралд ХЗХ-дын банкин

дахь хадгаламжийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад 128.7 хувиар өсч 23,537,042.1 мянган төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн хэмжээ 49.0 хувиар өссөн бөгөөд нийт чанаргүй зээлийн 94.3 хувийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын чанаргүй зээл эзэлж байна.

ХЗХ-дын тоо болон нийт активын өөрчлөлтийг харьцуулж үзүүлбэл :



3.2 Активын төвлөрлийг активын хэмжээ болон байршлаар нь авч үзвэл:

/Хүснэгт 10/(мянган төгрөгөөр)

№	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив		Гишүүдийн тоо	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	3	85,709,786.1	53.3%	13,361	23.17%
2	1,000,000.0 -10,000,000.0	16	41,027,234.5	25.5%	14,086	24.43%
3	500,000.0-1,000,000.0	8	5,549,904.7	3.5%	2,126	3.69%
4	100,000.0-500,000.0	151	24,435,435.6	15.2%	21,105	36.60%
5	50,000.0-100,000.0	32	2,380,983.7	1.5%	2,953	5.12%
6	10,000.0-50,000.0	51	1,578,807.6	1.0%	3,333	5.78%
7	10,000.0 хүртэл	27	86,436.5	0.1%	695	1.21%
	Нийт дүн	288	160,768,588.7	100%	57,659	100%

ХЗХ-дыг активын хэмжээгээр нь ангилахад томоохон буюу 1.0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 19 ХЗХ-ны нийт актив 126,737,020.6 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 78.8 хувийг, гишүүдийн тоо 27,447 байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 47.6 хувийг тус тус эзэлж байна.

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд ХЗХ-дын нийт зээлийн багц 117,942,219.5 мянган төгрөг байгаа нь активын 73.4 хувьтай, цэвэр зээл 114,751,354.9 мянган төгрөг байгаа нь активын 71.4 хувьтай тус тус тэнцэж байна. Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.9 хувь, дээд хүү 4.3 хувь, доод хүү 2.7 хувь байна.

ХЗХ-дыг зээлийн багцаар нь ангилж харуулбал:

/Хүснэгт 12/ (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Нийт зээлд эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	13	85,887,688.0	72.8%
2	500,000.0-1,000,000.0	10	8,196,001.5	6.9%
3	100,000.0-500,000.0	105	17,051,416.2	14.5%
4	50,000.0-100,000.0	62	4,946,770.2	4.2%
5	10,000.0-50,000.0	58	1,775,297.8	1.5%
6	10,000.0 хүртэл	18	85,045.7	0.1%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	22	-	-
	Нийт дүн	288	117,942,219.4	100%

Зээлийн багц нь 1,000,000.0 мянган төгрөгөөс дээш үлдэгдэлтэй 13 ХЗХ-ны нийт зээлийн хэмжээ 85,887,688.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 72.8 хувийг эзэлж байгаа бол зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй 22 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 7.6 хувийг эзэлж байна.

Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/График 9/


/График 10/



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ буурсан байгаа боловч ангилал буурч чанаргүй зээлийн хэмжээ 1.1 пунктээр өсч 5.7 хувьд хүрсэн байна.

Зээлийн багцын өөрчлөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:

/График 11/ (тэрбум төгрөгөөр)



Сүүлийн 5 жилд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ дунджаар 4.2 хувьтай байна.

ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар

Тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 14/ (мянган төгрөгөөр)


№	ЭХ ҮҮСВЭР	2017 I улирал		2018 I улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. ӨР ТӨЛБӨР		98,064,292.4	80.6%	132,461,572.3	82.4%	34,397,279.9	35.1%
1.1	ХАДГАЛАМЖ	74,658,800.4	61.3%	107,998,368.0	67.2%	33,339,567.6	44.7%
	Хугацаагүй	2,311,701.9	1.9%	3,420,789.7	2.1%	1,109,087.8	48.0%
	Хугацаатай	72,347,098.5	59.4%	104,577,578.3	65.0%	32,230,479.8	44.5%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	3,253,559.2	2.7%	5,381,708.6	3.3%	2,128,149.4	65.4%
	Банкнаас авсан зээл	1,671,740.8	1.4%	3,048,061.2	1.9%	1,376,320.4	82.3%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	48,689.8	0.0%	497,345.8	0.3%	448,656.0	921.5%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,533,128.6	1.3%	1,836,301.5	1.1%	303,172.9	19.8%
	Тогтворжилтын сангийн туслалцаа	-	-	-	-	-	-
1.3	БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,572,121.5	5.4%	7,710,796.5	4.8%	1,138,675.0	17.3%
	Цалингийн өглөг	53,290.4	0.0%	43,659.2	0.0%	(9,631.2)	-18.1%
	Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	256,924.1	0.2%	449,043.4	0.3%	192,119.3	74.8%
	Ногдол ашгийн өглөг	1,305,426.3	1.1%	224,695.2	0.1%	(1,080,731.1)	-82.8%
	Санхүүгийн түрээсийн өглөг	1,618.5	0.0%	975.0	0.0%	(643.5)	-39.8%
	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	26.6	-	-	0.0%	(26.6)	-100.0%
	Урьдчилж орсон орлого	115,262.3	0.1%	124,186.2	0.1%	8,923.9	7.7%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	4,746,335.5	3.9%	6,449,455.7	4.0%	1,703,120.2	35.9%
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	2,384.9	-	-	0.0%	(2,384.9)	-100.0%
	Бусад богино хугацаат өглөг	90,852.8	0.1%	418,781.8	0.3%	327,929.0	360.9%

1.4	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,579,811.3	11.2%	11,370,930.2	7.1%	(2,208,881.1)	-16.3%
	Банкнаас авсан зээл	439,839.7	0.4%	231,736.6	0.1%	(208,103.1)	-47.3%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	549,640.2	0.5%	298,339.7	0.2%	(251,300.5)	-45.7%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	12,389,197.1	10.2%	10,819,527.8	6.7%	(1,569,669.3)	-12.7%
	Тогтворжилтын сангийн туслалцаа	200,000.0	0.2%	-	0.0%	(200,000.0)	-100.0%
	Хойшлогдсон татварын өр төлбөр	1,134.3	-	21,326.1	0.0%	20,191.8	1780.1%
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		23,633,988.9	19.4%	28,307,016.3	17.6%	4,673,027.4	19.8%
2.1	ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ	13,421,049.0	11.0%	14,745,229.7	9.2%	1,324,180.7	9.9%
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	13,402,670.8	11.0%	14,700,387.1	9.1%	1,297,716.3	9.7%
	Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	18,378.2	0.0%	44,842.6	0.0%	26,464.4	144.0%
2.2	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	159,832.9	0.1%	167,637.8	0.1%	7,804.9	4.9%
	Дахин үнэлгээний нэмэгдэл	159,832.9	0.1%	167,637.8	0.1%	7,804.9	4.9%
2.3	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	10,053,107.1	8.3%	13,417,761.8	8.3%	3,364,654.7	33.5%
	Нөөцийн сан	3,104,991.6	2.6%	3,473,535.1	2.2%	368,543.5	11.9%
	Хандив, тусламж	192,904.4	0.2%	577,560.8	0.4%	384,656.4	199.4%
	Хадгаламж, хамгаалалтын сан	828,197.5	0.7%	1,072,010.5	0.7%	243,813.0	29.4%
	Нийгмийн хөгжлийн сан	738,599.8	0.6%	609,345.8	0.4%	(129,254.0)	-17.5%
	Тогтворжилтын сан	837,742.8	0.7%	1,061,678.0	0.7%	223,935.2	26.7%
	Бусад сангууд	921,651.2	0.8%	1,046,700.6	0.7%	125,049.4	13.6%
	Хуримтлагдсан орлого /алдагдал/	3,429,019.8	2.8%	5,581,400.9	3.5%	2,152,381.1	62.8%
	Тайлангийн үеийн цэвэр орлого	484,070.4	0.4%	463,601.7	0.3%	(20,468.7)	-4.2%
	Өмнөх үеийн цэвэр орлого	2,944,949.4	2.4%	5,095,196.0	3.2%	2,150,246.6	73.0%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		121,698,281.4	100%	160,768,588.7	100%	39,070,307.3	32.1%

ХЗХ-дын нийт өр төлбөр өмнөх оны мөн үеэс 35.1 хувиар, өөрийн хөрөнгө 19.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг харьцуулж харуулбал:

/График 12/ (тэрбум төгрөгөөр)



Сүүлийн 4 жилд ХЗХ-дын бусад өр төлбөрийн хэмжээ хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн дүнгээс давсан үзүүлэлттэй байна.

4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 107,998,368.0 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 67.2 хувийг эзэлж байгаа ба үүнээс 104,577,578.3 мянган төгрөг буюу 96.8 хувь нь хугацаатай хадгаламж, 3,420,789.7 мянган төгрөг буюу 3.2 хувь нь хугацаагүй хадгаламж байна. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.6 хувь, дээд хүү 1.8 хувь, доод хүү 1.3 хувь байна.


/Хүснэгт 15/ (мянган төгрөгөөр)

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	3	68,397,194.4	63.3%
2	1,000,000.0-10,000,000.0	10	23,750,630.7	22.0%
3	500,000.0-1,000,000.0	7	4,945,726.1	4.6%
4	100,000.0-500,000.0	32	6,125,481.8	5.7%
5	50,000.0-100,000.0	25	1,795,493.5	1.7%
6	10,000.0-50,000.0	112	2,630,932.8	2.4%
7	5,000.0-10,000.0	38	287,662.2	0.3%
8	5,000.0 хүртэл	30	65,246.6	0.1%
9	Хадгаламжгүй	31	-	
Нийт дүн		288	107,998,368.0	100%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 13 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 92,147,825.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 85.3 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 31 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 10.8 хувийг эзэлж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг харуулбал:

/График 13/(тэрбум төгрөгөөр)



Хадгаламжийн сүүлийн 4 жилийн дундаж өсөлт 19.3 хувьтай байна.

4.3 Бусдаас авсан зээл

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 75.6 хувийг эзэлж байна.

/Хүснэгт 17/ (мянган төгрөгөөр)

№	Бусдаас авсан зээл	Нийт	УБ хот	
			Дүн	Орон нутаг
1	Банкнаас авсан зээл	3,279,797.8	2,864,799.4	414,998.4
2	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	795,685.5	669,759.0	125,926.5
3	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	12,655,829.3	12,586,821.6	69,007.8
Нийт		16,731,312.7	16,121,380.0	609,932.7

4.4 Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 14,745,229.7 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 9.2 хувийг эзэлж байна.

/Хүснэгт 18/ (мянган төгрөгөөр)

№	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	
				Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	5,052	3,433,761.6	23.3%
2	500,000.0-1,000,000.0	2	1,384	1,117,188.9	7.6%
3	100,000.0-500,000.0	27	22,811	5,794,638.3	39.3%
4	50,000.0-100,000.0	18	5,354	1,277,080.6	8.7%
5	10,000.0-50,000.0	106	13,970	2,403,191.3	16.3%
6	5,000.0-10,000.0	80	6,765	580,019.8	4.0%
7	5,000.0 хүртэл	53	2,323	139,349.3	1.0%
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		288	57,659	14,745,229.7	100%

ХЗХ-дын хувь хөрөнгийн хэмжээг өмнөх жилүүдтэй харьцуулбал:

/График 14/ (тэрбум төгрөгөөр)



4.5 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2018 оны эхний улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 28,307,016.3 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 17.6 хувийг эзэлж байна. Үүнийг бүлэглэн харуулбал дараах байдалтай байна.

/Хүснэгт 20/ (мянган төгрөгөөр)

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	3	11,189,106.3	39.5%

2	500,000.0-1,000,000.0	8	4,942,076.0	17.5%
3	100,000.0-500,000.0	32	7,238,624.8	25.6%
4	50,000.0-100,000.0	28	2,026,623.1	7.2%
5	10,000.0-50,000.0	107	2,605,079.8	9.2%
6	10,000.0 доош	92	446,078.0	1.6%
7	Өөрийн хөрөнгөгүй	18	-140,571.8	-0.5%
Нийт өөрийн хөрөнгийн дүн		288	28,307,016.2	100%

ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг бүлэглэн харуулбал:

/Хүснэгт 22/ (мянган төгрөгөөр)

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	1	6,430,044.4	47.9%
2	500,000.0-1,000,000.0	2	1,816,518.3	13.5%
3	100,000.0-500,000.0	17	3,592,625.2	26.8%
4	50,000.0-100,000.0	10	719,374.5	5.4%
5	10,000.0-50,000.0	63	1,490,913.1	11.1%
6	5,000.0-10,000.0	35	251,283.9	1.9%
7	1,000.0-5,000.0	44	118,061.4	0.9%
8	1,000.0 хүртэл	32	13,518.7	0.1%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	84	-1,014,577.7	-7.6%
Нийт дүн		288	13,417,761.8	100%

Алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон 84 ХЗХ байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5-аар буурсан үзүүлэлт юм.

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

/Хүснэгт 23/ (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2017.I		2018.I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. ХҮҮГИЙН ОРЛОГО	6,447,135.5	93.0%	9,315,919.9	95.4%	2,868,784.4	44.5%
Зээлийн хүүгийн орлого	6,150,958.2	88.7%	8,976,445.6	91.9%	2,825,487.4	45.9%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	105,173.6	1.5%	129,835.4	1.3%	24,661.8	23.4%
Үнэт цаасны хүүгийн орлого	96.0	-	8,161.4	0.1%	8,065.4	8401.4%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	209,107.9	3.0%	398,221.2	4.1%	189,113.3	90.4%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого			201.7	0.0%	201.7	
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	18,200.3	0.3%	196,945.3	2.0%	178,745.0	982.1%
2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	186,905.6	2.7%	209,962.6	2.2%	23,057.0	12.3%

Элсэлтийн хураамж	10,806.0	0.2%	12,545.7	0.1%	1,739.7	16.1%
Гишүүний татвар	16,295.4	0.2%	15,173.4	0.2%	-1,122.0	-6.9%
Үйлчилгээний шимтгэл, хураамж	90,970.3	1.3%	166,620.4	1.7%	75,650.1	83.2%
Түрээсийн орлого	3,900.5	0.1%	3,580.0	0.0%	-320.5	-8.2%
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	64,933.4	0.9%	12,043.0	0.1%	-52,890.4	-81.5%
3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	300,169.3	4.3%	238,855.1	2.4%	-61,314.2	-20.4%
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	440.5	-	440.5	0.0%		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз			28,562.4	0.3%		
Үнэт цаасны арилжааны орлого			9,261.5	0.1%		
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого			0.0	0.0%		
Торгуулийн орлого			933.6	0.0%		
Бусад орлого	299,728.7	4.3%	199,657.1	2.0%	-100,071.6	-33.4%
НИЙТ ОРЛОГО	6,934,210.4	100%	9,764,737.6	100%	2,830,527.2	40.8%

ХЗХ-дын нийт орлого өмнөх оны мөн үеэс 2,868,784.4 мянган төгрөгөөр буюу 44.5 хувиар өсөж 9,315,919.9 мянган төгрөгт хүрсэн байна.

5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 24/ (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2017.I		2018.I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. ХҮҮГИЙН ЗАРДАЛ	3,492,883.0	54.2%	5,289,567.9	56.9%	1,796,684.9	51.4%
Хадгаламжийн хүүгийн зардал	3,391,725.5	52.6%	5,141,195.6	55.3%	1,749,470.1	51.6%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	87,714.0	1.4%	131,491.6	1.4%	43,777.6	49.9%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	2,165.6	-	2,821.7	0.0%	656.1	30.3%
Бусад хүүгийн зардал	11,804.8	0.2%	18,003.5	0.2%	6,198.7	52.5%
(Хүүгийн зардлын буцаалт)	527.0	-	3,944.5	0.0%	3,417.5	648.5%
2. БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	794,304.7	12.3%	1,069,348.1	11.5%	275,043.4	34.6%
Зээлийн эрсдэлийн зардал	811,273.1	12.6%	1,137,367.2	12.2%	326,094.1	40.2%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	4,745.2	0.1%	34,542.0	0.4%	29,796.8	627.9%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	21,713.6	0.3%	102,561.1	1.1%	80,847.5	372.3%
3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,035,819.1	31.6%	2,658,000.0	28.6%	622,180.9	30.6%
Боловсон хүчний зардал	1,270,611.9	19.7%	1,720,044.9	18.5%	449,433.0	35.4%
Бусад төрлийн зардал	765,207.3	11.9%	937,955.1	10.1%	172,747.8	22.6%

4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	36,429.1	0.6%	138,717.5	1.5%	102,288.4	280.8%
Торгуулийн зардал			1,261.0	0.0%	1,261.0	
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз			16,589.2	0.2%	16,589.2	
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз			33,370.9	0.4%	33,370.9	
Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз			19,413.2	0.2%	19,413.2	
Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз				0.0%	0.0	
Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз			20,757.3	0.2%	20,757.3	
Үйл ажиллагааны бус бусад зардал			47,255.6	0.5%	47,255.6	
Татварын зардал	90,704.0	1.4%	146,231.2	1.5%	55,527.2	61.2%
НИЙТ ЗАРДАЛ	6,450,139.9	100%	9,301,864.7	100%	2,851,724.8	44.2%

ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 9,301,864.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлоготой уялдан 2,851,724.8 мянган төгрөгөөр буюу 44.2 хувиар өссөн байна.

5.3 Ашигт ажиллагаа

Ашигт ажиллагааг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/График 15/ (тэрбум төгрөгөөр)



ХЗХ-дын нийт орлого сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа боловч цэвэр орлого өсөлтгүй байгаа нь зардлын хэмжээ өндөр байгаатай холбоотой байна.

5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

Тайлант улиралд 183 ХЗХ 1,355,129.9 мянган төгрөгийн ашигтай, 19 ХЗХ ашиг, алдагдалгүй, 87 ХЗХ 892,257.1 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 462,872.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21,197.5 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ашигтай ажилласан ХЗХ-дыг ашгийн хэмжээгээр бүлэглэн харуулбал дараах байдалтай байна.

/Хүснэгт 25/ (мянган төгрөгөөр)

Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Активын хэмжээ	Активын өгөөж
100,000.0 дээш	2	637,773.6	47.1%	70,637,980.2	0.9%
50,000.0-100,000.0	1	61,749.2	4.6%	1,159,206.5	5.3%
10,000.0-50,000.0	16	362,433.5	26.8%	36,183,038.2	1.0%
5,000.0-10,000.0	18	124,280.6	9.2%	9,121,463.5	1.4%
1,000.0-5,000.0	62	141,074.8	10.4%	18,925,133.1	0.7%
1,000.0 хүртэл	83	27,818.2	2.1%	7,656,743.7	0.4%
Ашиг, алдагдалгүй	20	0	0.0%	527,871.3	0.0%
Нийт дүн	202	1,355,129.9	100%	144,211,436.5	

5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

Нийт 288 ХЗХ-ны 29.9 хувь буюу 86 ХЗХ 891,528.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үеэс 8-аар буюу 2.8 хувиар буурчээ.

/Хүснэгт 27/ (мянган төгрөгөөр)

№	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	10,000.0 дээш	8	-756,479.9	84.9%
2	5,000.0-10,000.0 хүртэл	5	-34,314.2	3.8%
3	1,000.0-5,000.0 хүртэл	37	-85,164.2	9.6%
4	1,000.0 хүртэл	36	-15,570.0	1.7%
	Нийт дүн	86	-891,528.3	100%

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2018 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

/Хүснэгт 29/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ /ДМУ	БАЙВАЛ ЗОХИХ	Үзүүлэлт хангаагүй ХЗХ-дын тоо	Үзүүлэлт хангаагүй ХЗХ-дын хувь
А	ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/		-	20 ХЗХ дутуу байгуулсан.	6.9%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	5%-аас хэтрэхгүй	30	10.4%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	ДМУ	30%-аас хэтрэхгүй	68	23.6%

4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	ДМҮ	30%-аас хэтрэхгүй	11	3.8%
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	60%-85%	137	47.6%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	ДМҮ	10%-аас хэтрэхгүй	19	6.6%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	ЗХШҮ	20%-80%	139	48.3%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	ДМҮ	20%-аас хэтрэхгүй	117	40.6%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	ЗХШҮ	10%-аас хэтрэхгүй	7	2.4%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	ЗХШҮ	5%-аас доошгүй	147	51.0%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	ДМҮ	-	32	11.1%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	ДМҮ	-	32	11.1%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	ДМҮ	-	38	13.2%
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	ДМҮ	15%-аас хэтрэхгүй	8	2.8%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	ЗХШҮ	5%-аас доошгүй	70	24.3%
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж				0.3

Нийт ХЗХ-дын 51.0 хувь нь хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 47.6 хувь нь нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 48.3 хувь нь гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 40.6 хувь нь бусдаас авсан зээлийн зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

/Хүснэгт 30/

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-дын тоо	ХЗХ-дын тоонд эзлэх хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	54	19.6%
2	1 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	56	20.3%
3	2 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	64	23.2%
4	3 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	55	19.9%

5	4 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	39	3.9%
6	5 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	8	0.7%
	Нийт дүн	276	100%

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 288 ХЗХ-ноос 90.3 хувь нь бүрэн хамрагдсан бол 9.7 хувь нь өмнөх улирлын санхүүгийн тайлан мэдээгээр хамрагдлаа.

ХЗХ-дын статистик үзүүлэлт

Тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын эрхэлж буй санхүүгийн ажил үйлчилгээг авч үзвэл тайлант хугацаанд ХЗХ-дын 41.0 хувь нь төслийн санхүүжилтийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй, 0.7 хувь нь санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 0.7 хувь нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 9,741 буюу 20.3 хувиар өссөн ба Улаанбаатар хотын гишүүд 34.5 хувиар, орон нутгийн гишүүд 0.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд ХЗХ-доос ирүүлсэн мэдээгээр нийт ХЗХ-дын 26.7 хувь нь санхүүгийн програм хангамжтай байгаа нь санхүүгийн байгууллагын хувьд хангалтгүй тоон үзүүлэлт бөгөөд ХЗХ-ны онцлогт тохирсон хямд өртөгтэй програм хангамжийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа нь 2017 онд зохион байгуулсан бүсчилсэн сургалтын үеэр хийсэн судалгаагаар харагдаж байсан.

Салбарын санхүүгийн үзүүлэлт

Санхүүгийн нэгтгэлээр ХЗХ-ны салбарын нийт актив **160,768,588.7** мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.6 хувийг, нийт зээлийн үлдэгдэл **117,942,219.5** мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.8 хувийг, чанаргүй зээлийн үлдэгдэл **6,682,613.3** мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.5 хувийг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл **107,998,368.0** мянган төгрөг нь банкны салбарын 0.7 хувийг тус тус эзэлж, ХЗХ-дын нийт хувь хөрөнгийн үлдэгдэл **14,745,229.7** мянган төгрөг, **13,417,761.8** мянган төгрөгийн хоршоологчдын өмчийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд **9,764,737.6** мянган төгрөгийн орлого олж, **9,301,864.7** мянган төгрөгийн зардал гарч **462,872.9** мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна.

Хөрөнгийн бүтэц, зээлийн үйл ажиллагаа

ХЗХ-ны салбарын 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар хөрөнгийн бүтцийн 73.4 хувийг зээл, 20.9 хувийг мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна. Тайлант хугацаан дахь банкинд байршуулсан хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 128.7 хувиар өссөн байна.

Тайлант хугацаан дахь ХЗХ-ны салбарын зээлийн ангиллыг авч үзвэл нийт зээлд эзлэх хэвийн зээл 90.7 хувь, хугацаа хэтэрсэн зээл 3.6 хувь, чанаргүй зээлийн хэмжээ 5.7 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 4,484,903.8 мянган төгрөгөөс 6,682,613.3 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 49.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт

чанаргүй зээлийн 94.3 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дынх байгаа тул Хорооноос ХЗХ-дын эрсдэлийг бууруулж дээрх ХЗХ-дод газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Зээлийн жигнэсэн дундаж хүү 2.9 хувь, дээд хүү 4.3 хувь, доод хүү 2.7 хувьтай байна.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

Тайлант хугацаан дахь ХЗХ-ны салбарын нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн 67.2 хувийг хадгаламж, 7.1 хувь нь урт хугацаат өр төлбөр, 9.2 хувийг гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, 8.3 хувийг хоршоологчдын өмч тус тус эзэлж байна. ХЗХ-ны гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 96.8 хувийг хугацаатай хадгаламж, 3.2 хувийг хугацаагүй хадгаламж эзэлж байгаа бөгөөд урт хугацаат өр төлбөрийн 95.2 хувь нь төсөл, хөтөлбөрөөс авсан зээл байна. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.6 хувь, дээд хүү 1.8 хувь, доод хүү 1.3 хувь байна. Салбарын хувьд гишүүдийн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 67.2 хувиар өссөн нь иргэдийн ХЗХ-дод итгэх итгэл нэмэгдэж байгааг харуулж байна. Цаашид салбарын эрсдэлийг бууруулахын тулд хадгаламжийн даатгалын асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна.

Мөн тайлант хугацаанд салбарын хэмжээнд хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн хэдий ч алдагдалтай ажиллаж, өөрийн хөрөнгөгүй болсон нэр бүхий 18 ХЗХ-нд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56.5-д “Санхүү төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон тухай бүр ХЗХ-ны үйл ажиллагаанд Хорооноос хяналт шалгалтыг хийнэ” заасны дагуу газар дээрх иж бүрэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тус улиралд өмнөх тайлант хугацааны тайлангаар өөрийн хөрөнгөгүй болсон 6 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Орлого, зарлага

Тайлант хугацаанд ХЗХ-ны салбарын нийт орлогын 95.4 хувийг хүүгийн орлого, 2.4 хувийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 56.9 хувийг хүүгийн зардал, 28.6 хувийг үйл ажиллагааны зардал тус тус эзэлж байна. Салбарын хэмжээнд ашигтай ажилласан үзүүлэлттэй байгаа боловч ХЗХ-дын 30.2 хувь нь алдагдалтай ажилласан байна. Хорооноос салбар дахь алдагдлыг бууруулахын тулд алдагдалтай ажилласан ХЗХ-дын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс ХЗХ-дын 47.6 хувь нь нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 24.3 хувь нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг, 51.0 хувь нь хоршоологчдын өмчийн зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР